



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2019

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

www.dornogovi.audit.mn



АГУУЛГА

Дэс дугаар	Агуулга, бүлгийн нэр	Хуудасны дугаар
1	1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	3
2	2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	4
3	2.1 Төсвийн шууд захирагчийн тайлан	5
4	2.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан	6
5	2.3 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан	7
6	2.4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
7	2.5 ТШЗ, ТТЗ, ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэх	8
8	3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	9
9	3.1 Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар/	9
10	3.2 Аймгийн ОНТ-ийн татварын бус орлого бүрдүүлэх үйл ажиллагааны үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудит	9
11	3.3 Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудит	10
12	4. НИЙЦЛИЙН АУДИТ	10
13	4.1 Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт сэдэвт нийцлийн аудит	11
14	4.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сэдэвт нийцлийн аудит	12
15	4.3 Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр үйл ажиллагаа нь газрын тухай хуульд нийцсэн эсэх сэдэвт нийцлийн аудит	12
16	5. ИТХ-ЫН ЗАХИАЛГА, ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ	13
17	5.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудит	13
18	5.2 Орон нутгийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны үр дүн гүйцэтгэлийн аудит	13
19	5.3 Дорноговь аймагт гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой МУ-д мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн сэдэвт нийцлийн аудит	13
20	Аймгийн хэмжээнд Ашигт малтмалын тухай хууль хэрэгжиж буй байдал сэдэвт нийцлийн аудит	14
21	6. ДОТООД АЖИЛ	14
22	6.1 Дотоод сургалт	14
23	6.2 Архив, бичиг хэрэг	15
24	6.3 Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа	15
25	6.4 Дотоод зохион байгуулалтын бусад асуудал	15
26	7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	16
27	8. ДҮГНЭЛТ, САНАЛ	17
28	8.1 Дүгнэлт	17
29	8.2 Санал	18



Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУ	Монгол улс
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
НААҮОНӨХХК	Нийтийн аж ахуйн үйлчилгээ, орон нутгийн өмчийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДС	Нийгмийн даатгалын сан
НХХЯ	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЯ	Сангийн яам
ТАГ	Төрийн аудитын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХАК	Хувийн аудитын компани
ХБГ	Хүлээгдэж байгаа гүйцэтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ШГ	Шууд гэрээ
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

1 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторын дэвшүүлсэн “Аудитыг баримтжуулах бодлого, арга зүйг боловсронгуй болгож төлөвшүүлэх” зорилтын хүрээнд 2019 онд нийт 40 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын Ерөнхий аудитор тус байгууллагын бүтэц орон тоог 11 байхаар баталсан бөгөөд 2019 оны эхний хагас жилийн байдлаар санхүү, гүйцэтгэл, нийцлийн алба болон дэмжих баг гэсэн бүтцээр, 9 орон тоотой, нийт 14660 хүн/өдөр, 2774 илүү цаг ажиллалаа.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 5 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, улс, орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн 217 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 117814,54 сая төгрөгийн 663 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 72403,6 сая төгрөгийн 120 алдааг залруулж, 187,9 сая төгрөгийн зөрчилд 72 төлбөрийн акт тогтоож, 14288,5 сая төгрөгийн зөрчилд 87 албан шаардлага хүргүүлэн, 29422,1 сая төгрөгийн зөрчилд 366 зөвлөмж, 18,4 сая төгрөгийн зөрчилд 52 албан тушаалтанд хариуцлага тооцох 13 санал хүргүүлж, 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт



Тайлант хугацаанд төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг хангуулж, улс, орон нутгийн төсөвт нийт 309,6 сая төгрөгийг төвлөрүүлж ажиллалаа.

Дорноговь аймгийн 2020 оны төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын саналын хэрэгцээ шаардлагыг үнэн зөв тодорхойлсон эсэхийг судлан, судалгааг УАГ-т хүргүүллээ. Аймгаас хүргүүлсэн төсвийн төсөлд нийт 85.0 тэрбум төгрөгийн 101 ажил тусгасан бөгөөд УИХ-д өргөн барьсан хөрөнгө оруулалтын жагсаалтад 8.3 тэрбум төгрөгийн 9 ажил тусгагдсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит 12 дугаар хуралдаан 2019 оны 12 дугаар сарын 04-ны өдөр хуралдаж, хуралдаанд аймгийн ТАГ-аас “Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх дараах 5 саналыг орууллаа. Үүнд:

1. Төсвийн төсөлд тусгасан 1120.2 сая төгрөгийн 3 хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн төсөлд тооцооллыг боловсруулан, хавсралтаар оруулах.
2. Төсвийн төслийг боловсруулах талаар СЯ-аас ирүүлсэн зарчим, чиглэлийг баримталж төсвийн төслийг боловсруулах.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 838.3 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж төлөвлөх.
4. Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах чиг үүргийг төлөвлөж, хэрэгжүүлэх. /Төсвийн төсөлд улсын төсөвт 1732.8 сая төгрөгийн 22 төсөл арга хэмжээг тусгасан/
5. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд зураг, төсөв нь батлагдсан, техник эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн арга хэмжээг төлөвлөх. Зураг төсөв батлагдаагүй 1816.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант хугацаанд 1327.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 25 санхүүгийн бус үр өгөөж тус тус тооцсон бөгөөд 1 төгрөгт ногдох үр өгөөж 5.2 төгрөг болж байна.

2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 217 байгууллага, тусгай сангуудыг аудитад хамруулахаас 41,5 хувь буюу 90 тайланд Төрийн аудитын газар, 58,5 хувь буюу 127 тайланд ХАК-иуд дүгнэлт гаргаж, түүвэрт хамруулсан байна.



127

Хувийн хэвшлийн
хараат бус аудитын
компани



90

Төрийн аудитын
байгууллага

Нийт 217 байгууллага

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2017 оны А/191 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг үндэслэн хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулж Сайн аудит ХХК, Мөнгө нөөц аудит ХХК, Ингүүмэл жаргалант аудит ХХК-иудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 129 шууд захирагч, 14 төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит 6 аж ахуйн нэгж, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, нийт 150 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 67 шууд захирагч болон ЗГТС-ийн тайланг түүвэрт хамрууллаа.




Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 106681,1 сая төгрөгийн 568 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 72403,6 сая төгрөгийн 120 алдааг залруулж, 166,7 сая төгрөгийн зөрчилд 67 төлбөрийн акт тогтоон, 11696,5 сая төгрөгийн зөрчилд 63 албан шаардлага, 22395,9 сая төгрөгийн зөрчилд 304 зөвлөмж хүргүүлээ. Мөн хязгаарлалттай, сөрөг, татгалзсан дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох 52 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 13 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 2 байгууллагын асуудлыг шилжүүлээ.

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг авч үзэхэд 130,9 сая төгрөгийн 44 төлбөрийн акт барагдаж, биелэлт 78,5 хувьтай, 6662,58 сая төгрөгийн 55 албан шаардлага хэрэгжиж, биелэлт 56,9 хувьтай, 20226,13 сая төгрөгийн 295 зөвлөмж хэрэгжиж, биелэлт 90,3 хувийн хэрэгжилттэй байна.

2.1 Төсвийн шууд захирагчийн тайлан

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 129 төсвийн **Шууд захирагчийн** санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 67 санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа. Тус аудитаар 103 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 21 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 2 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгч, 3 байгууллагад санал дүгнэлт өгөхөөс татгалзлаа.

129 – ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА



Санхүүгийн тайлангийн аудитаар оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчлийн улмаас “Хязгаарлалттай”, “Сөрөг”, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”, нийт 26 дүгнэлт өгсөн ба тус дүгнэлтийг өгөхөд нөлөөлсөн зөрчлийг ангилж үзвэл дараах байдалтай байна. /сая төгрөгөөр/



Төсвийн шууд захирагчийн тайланд 11825,3 сая төгрөгийн 415 алдаа зөрчил илрүүлж, 1727,4 сая төгрөгийн 68 алдааг аудитын явцад залруулан, 123,0 сая төгрөгийн зөрчилд 62 төлбөрийн акт тогтоож, 1057,6 сая төгрөгийн зөрчилд 49 албан шаардлага хүргүүллээ. Мөн төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналттай холбоотой 8898,8 сая төгрөгийн зөрчилд 230 зөвлөмж өгч, хязгаарлалттай санал дүгнэлт авсан 41 төсвийн шууд захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүллээ.

Тайлант хугацаанд 95,7 сая төгрөгийн төлбөрийн акт барагдаж, 967,1 сая төгрөгийн албан шаардлага, 8082,7 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжсэн байна.

2.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан

МУ-ын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасан цаглабарт хугацаанд 14 төсвийн **Төвлөрүүлэн захирагчийн** тайланд дүгнэлт гаргаж, 10 тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 4 сумын төвлөрүүлэн захирагчийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн.

1. **Алтанширээ сум ТТЗ:** Алтанширээ сумын ЗДТГазар нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”, Эрүүл мэндийн төв нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, Ерөнхий боловсролын сургуулийн аудитаар илэрсэн алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.
2. **Замын Үүд сум ТТЗ:** Төсвийн шууд захирагчийн 3 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн, төвлөрүүлэн захирагч өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, сумын төсвийн нийт орлогын төлөвлөгөөг 30.9 сая төгрөгөөр тасалсан, аймагт төвлөрүүлэх орлогыг 28.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахдаа МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалыг баримтлахгүйгээр 864.2 сая төгрөгийн зардал зарцуулсан байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.
3. **Дэлгэрэх сум ТТЗ:** Дэлгэрэх сумын ЗДТГазар нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”, Ерөнхий боловсролын сургуулийн алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.
4. **Өргөн сум ТТЗ:** Сумын ЗДТГ нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”, Ерөнхий боловсролын сургуулийн алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй.

Аудитаар 4009.6 сая төгрөгийн 54 алдаа зөрчил илрүүлж, 2965.2 сая төгрөгийн 30 алдааг залруулан, 28,9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 10.7 сая төгрөгийн 6 албан шаардлага, нийт 1004.8 сая төгрөгийн 15 зөвлөмжийг хүргүүллээ.

Тайлант хугацаанд 28,9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт барагдаж, 10,7 сая төгрөгийн албан шаардлага, 1004.8 сая төгрөгийн 14 зөвлөмж хэрэгжсэн байна.

2.3 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар Орон нутгийн өмчит 6 аж ахуйн нэгжийн тайланд дүгнэлт гаргаж, 4 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 2 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.

1. *Замын-Үүд сум дахь Чандмань бадрал ОНӨ ХХК*: Бэлэн мөнгөний үлдэгдэл дутагдсан, НББ-д бүртгэлтэй хөдлөх хөрөнгө өөр байгууллагын эзэмшлийнх, татварын тайланг бүрэн тайлагнаагүй, тайлант онд нийт 679,8 мянган төгрөгийг харилцах данснаас чекээр гарган авч шууд худалдан авалт хийсэн, бэлэн мөнгөний зарцуулалтад хяналт тавиагүйгээс нийт 26,5 сая төгрөг дутагдал гаргасан байхад хяналт тавьж ажиллаагүй, тооцоог сар бүр бодоогүй, кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээний тайланг хийж хэвшээгүй, мөнгөн кассаар ажиллаж байсан албан тушаалтнуудтай холбоотой тооцоог дараа тооцооны авлагаар бүртгээгүй, бэлэн мөнгөөрх худалдан авалтад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, мөнгөн хөрөнгө ашиглах боломжийг бүрдүүлж, ашиглалтгүй бараа материалын үлдэгдлийг нэмэгдүүлсэн, орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн өрсөлдөх боломжийг хязгаарласан зэрэг нийт 1057,8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, хэмжилт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүйгээс тус компаний санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн.
2. *Нийтлэг үйлчилгээний газар*: 2006 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 01 тоот шийдвэрээр бүртгүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын хариуцлагын хэлбэрийг төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж заасан байхад МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан УСНББОУСтандарт, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2015 оны 07 тоот тушаалаар баталсан төсвийн ангилал, Сангийн сайдын 2017 216 тоот тушаалаар баталсан журам, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаагүй, ААНБ-д мөрдөх НББ-ийг үндэслэн санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан тул НҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар 22873,1 сая төгрөгийн 63 алдаа зөрчил илрүүлж, 0,8 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 14,8 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 10628,1 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, нийт 12229,3 сая төгрөгийн 50 зөвлөмж хүргүүллээ.

2.4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагч, орон нутгийн төсөвт болон тусгай шилжүүлгийн, ОНӨХХК, төсөл, сангуудын нийт 235 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. ТЕЗ-ийн тайланд дараах зөрчил илэрлээ.

- Засаг даргын нөөц хөрөнгөөс 60,3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн,
- Төсвийн тухай хуулийг зөрчин тухайн шатны төсөвт хамаарахгүй байгууллагад 102,0 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт олгосон,
- Төрийн сангийн үйл ажиллагаанд НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан “мэдээлэл боловсруулах үйл ажиллагаа”-ны дагуу журнал хөтлөөгүй,
- Аймгийн ИТХурал, Замын-Үүд сумын ИТХ “орон нутгийн нөөц хөрөнгө” гэсэн зориулалтаар бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангилалд нийт 161.0 сая төгрөгийг батлуулж зарцуулсан,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс 30 хувь буюу 240.0 сая төгрөгийг нөөц болгож үлдээлгүй тайлант онд зарцуулсан байна.

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 67973,2 сая төгрөгийн 38 алдаа зөрчил илэрч, 67710,2 сая төгрөгийн 21 алдааг залруулан, 263,0 сая төгрөгийн 9 зөвлөмжийг хүргүүллээ.

ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн аудитаар 62412,8 сая төгрөгийн орлого, 61943,1 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлийг баталгаажуулж, нийт 5 зөвлөмж хүргүүлсэн.

2.5 ТШЗ, ТТЗ, ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэх

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудиторын 2019 оны А/19 тоот тушаалаар төлөвлөлтийн үе шатны хуваарийг баталж, төлөвлөгөөний дагуу ТШЗ-ийн 43, ТТЗ-ийн 3, ЗГТС-ийн 27 тайлангийн төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэж, СТАУС программд төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатны ажлыг оруулаад байна.

Төлөвлөлтийн буюу завсрын аудитаар 2.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээд байна.

3 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 үйл ажиллагааны төлөвлөгөөнд жилийн эцсийн байдлаар нийт 5 гүйцэтгэлийн аудит хийхээр тусгагдсан бөгөөд УАГ-ын нэгдсэн удирдамжаар 3 аудит, өөрсдийн санаачилгаар 2 аудитыг хийж гүйцэтгэлээ.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 7470,5 сая төгрөгийн 51 зөрчил илрүүлж, 19,8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1680,7 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 4275,8 сая төгрөгийн зөрчилд 35 зөвлөмж хүргүүлж, 1195,6 сая төгрөгийн 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Тайлант хугацаанд 19,8 сая төгрөгийн төлбөрийн акт барагдаж, 40,5 сая төгрөгийн 9 албан шаардлага хэрэгжин, 1766,1 сая төгрөгийн 19 зөвлөмж хэрэгжсэн байна.

3.1 Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /УАГ-ын нэгдсэн удирдамжаар/

Аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамж, ТАГ-ын 2019 оны төлөвлөгөөний дагуу 2019.01.01-2019.04.10-ны хугацаанд гүйцэтгэлээ. Тус аймагт 23.4 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эрх шилжүүлэн, 4.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгохоор шийдвэрлэсэн байна.

Аудитаар Орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийг жагсаалт батлагдсаны дараа боловсруулж, баталгаажуулсан, их засварын ажлыг төлөвлөхдөө мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслээгүй, эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хугацаа алдсан, тендерийн баримт бичгийг журмын дагуу боловсруулаагүй, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Мөн гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу гүйцэтгээгүй байхад комисс хүлээн авсан, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй, хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, бодит үр нөлөөг тооцоогүй байна.

Аудитаар нийт 1999,1 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлж, 1675,0 сая төгрөгийн 3 албан шаардлага өгснөөс 35.0 сая төгрөгийн 2 албан шаардлага биелэж, 324,1 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлж хэрэгжилт 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн байна.

3.2 Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудит

Аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамжаар 2019.09.16-2019.11.15 хүртэлх хугацаанд гүйцэтгэж, аудитаар “НДС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт сайжирснаар зөрчил буурсан байна” гэсэн дүгнэлтийг өглөө.



Аудитаар НДШ-ийн орлогыг бодитой тооцож хуваарилаагүйгээс сан хооронд шилжүүлэн зарцуулсан, байгууллагуудтай мэдээлэл солилцох байдал, албан хаагчдын мэдлэг чадвар, ажлын хариуцлагатай холбоотой зөрчил гарсан, ЭМДС-аас үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг даатгуулагчдад сурталчилан таниулах үйл ажиллагаа хангалтгүй байгаагаас иргэд хууль тогтоомжоор олгосон эрхээ бүрэн эдэлж чадаагүй, хөнгөлөгдөж байгаа эмийн тоо, хөнгөлөх хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой эмийн сангуудад олгохоор батлагдсан санхүүжилт хүрэлцдэггүй байна.

Аудитаар 449.1 сая төгрөгийн 8 зөрчил илрүүлж үүнд 6 зөвлөмж хүргүүлээ. Мөн иргэдэд олгох тэтгэвэр тэтгэмжийг хууль тогтоомжид заасны дагуу олгуулах 1 албан шаардлага хүргүүлээ.

3.3 Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудит

Аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамжаар 2019.09.17-2019.11.01 хүртэлх хугацаанд гүйцэтгэж, “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн хуваарилалтыг оновчтой шийдвэрлэх бодлого дутагдаж байна” гэсэн дүгнэлт өглөө.

СӨБ-ын талаарх бодлого оновчтой байгаа ч холбогдох яамдын Сайд хуулинд заасан дүрэм, журмыг бүрэн боловсруулаагүйгээс хэрэгжүүлэх эрх зүйн орчин хангалтгүй, боловсролын үйл ажиллагааны бодлого, хөгжлийн төлөвлөлтийн асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулагдаагүй, орон нутгийн Боловсролын газрын ажиллах журмыг боловсруулж ажиллаагүй байна. Мөн нэг багшид ногдох хүүхдийн тооны норматив болон цэцэрлэгийн хүчин чадлаас хэтрүүлж хүүхэд авсан, мэргэжлийн багшийн хүрэлцээ дутмаг зэрэг асуудал нь хүүхдүүдэд насан туршийн боловсролын суурь чадварыг бүрэн эзэмшүүлэх үйл ажиллагааны үр дүнг бууруулах эрсдэлтэй байна.

Аудитаар 301.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 3.3 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулан, хүүхдийн хоолны зардлын хэмнэлт 298.6 сая төгрөгийг бусад зардалд зарцуулсан зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага бичсэн.

4 НИЙЦЛИЙН АУДИТ

Аймгийн Төрийн аудитын газрын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 5 нийцлийн аудит хийхээс УАГ-ын нэгдсэн удирдамжаар 3 аудитыг гүйцэтгэлээ.

Нийцлийн аудитаар нийт 3662,9 сая төгрөгийн 44 зөрчил илрүүлж, 1,4 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 911,2 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 2750,3 сая төгрөгийн зөрчилд 27 зөвлөмж хүргүүлсэн.

Тайлант хугацаанд 0,4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт барагдаж, 865,8 сая төгрөгийн 11 албан шаардлага хэрэгжин, 7 зөвлөмж хэрэгжсэн байна.

4.1 “Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт” сэдэвт нийцлийн аудит

Аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамжаар 2019 оны 03 сарын 01-ний өдрөөс 04 сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэж, “Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад холбогдох хууль, тогтоомжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна” гэсэн дүгнэлт өглөө.

2018 онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 2761.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 ТАХ хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 2688.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 86 ТАХ бүрэн хэрэгжиж, 141.5 сая төгрөгийн төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 ТАХ дутуу хэрэгжсэн байна.

Аудитаар Сайншанд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ТАХ нь тухайн оны сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй, 2018 онд хэрэгжүүлсэн ТАХ-ны техникийн тодорхойлолтыг хангалтгүй боловсруулсан, сумдад хөрөнгө оруулалтын ажлуудад мэргэжлийн байгууллагын хяналт тавигдаагүй, захиалагчийн хяналт чанартай хийгдээгүй, хяналтыг тогтмол хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө оруулалтын ажлууд нь холбогдох норм дүрэм, чанарын баталгааг хангаагүй, барилга угсралт, засвар, гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, инженерийн хийцтэй болон гар худаг гаргах зэрэг ажлуудад ил, далд ажлын актыг үйлдээгүй, орон нутгийн хөгжлийн сангийн зааварт заасан чиг үүрэгт хамаарахгүй болон урсгал зардлын шинжтэй ТАХ-г хэрэгжүүлсэн, гүйцэтгэлийг бүрэн хянаагүйгээс санхүүжилтийг илүү олгосон, 111.6 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгээгүй байна. Мөн өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжээгүй зэрэг зөрчил илэрлээ.

Аудитаар нийт 2928,5 сая төгрөгийн 15 зөрчил илрүүлж, 1,4 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоосноос 0.4 сая төгрөгийн акт биелсэн, 176,8 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгснөөс 131.4 сая төгрөгийн 2 албан шаардлага хэрэгжсэн байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн 2750,3 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ.

4.2 “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудит

Тус аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамж, аймгийн ТАГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 2019.02.26-2019.04.01 хүртэлх хугацаанд гүйцэтгэж “Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна” гэсэн дүгнэлт өглөө. Аудитад улс, орон нутгийн төсвийн 173 байгууллагыг хамруулан, 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ-ууд шилэн дансны нэгдсэн системд цахим хуудас нээлгээгүй, холбогдох мэдээллийг мэдээлээгүй байна.

Замын-Үүд сумын Ухаалаг багачууд, Жаргалан, Гурван билэг, Болор-Эрдэнэ цэцэрлэгүүд, Үлэмж тэнгэр ерөнхий боловсролын сургууль, Сайншанд сумын Төмөр замын МСҮТ зэрэг аж ахуйн нэгж байгууллагууд шилэн дансны цахим хуудас хөтлөөгүй, мэдээлэл огт оруулаагүй, шилэн дансны нэгдсэн системд улс, орон нутгийн төсвийн байгууллагууд бүрэн хамрагдсан ч хуульд заасан мэдээллүүдийг бүрэн оруулах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аудитаар 642,6 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлж, 642,6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага тогтоож, 1 албан шаардлага хэрэгжсэн байна.

Мөн Сангийн яаманд шилэн дансны нэгдсэн системийг боловсронгуй бөгөөд энгийн болгох талаар саналыг уламжилж, аймгийн Засаг дарга, Сайншанд сумын Засаг даргад хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар 6 зөвлөмж хүргүүлж хэрэгжилт 50 хувьтай буюу 3 зөвлөмж хэрэгжсэн байна.

4.3 “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр үйл ажиллагаа нь газрын тухай хуульд нийцсэн эсэх” сэдэвт нийцлийн аудит

Аудитыг ЯАГ-ын нэгдсэн удирдамжаар 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэж “Үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөө байхгүйгээс тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулахад хүндрэлтэй байна” гэсэн дүгнэлт өглөө.

2018 оны жилийн эцсийн байдлаар Дорноговь аймгийн хэмжээнд нийт газар нутгийн 78 хувийг эзэмшлээр, 22 хувийг ашиглалтаар, 0.004 хувийг өмчлөлөөр ашиглаж байна.

Аудитаар газар зохион байгуулалтын үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөө байхгүйгээс хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг цаашид хэрхэн баримталж, хэрэгжүүлэх нь тодорхойгүй, тухайн жилд төлөвлөсөн хэмжээнд газар олголт хийгдээгүй, 2015-2018 онд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газрыг олгоходоо тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахгүйгээр өмнөх оны төлөвлөгөөг үндэслэн олгосон, зарим сумдад 2015-2016 онд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр 10.6 га газрыг шууд олгосон, Орон нутгийн тусгай хэрэгцээний газарт гэрээ байгуулан худалдаа үйлчилгээ эрхэлсэн, аймгийн хэмжээний 14 суманд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 6093 иргэн, ААНБ нь 47.9 сая төгрөгийн газрын төлбөрийг төлөөгүй, иргэд гэр бүлийн хэрэгцээний газрынхаа тодорхой хэсгийг холбогдох шийдвэргүйгээр зориулалтыг өөрчлөн худалдаа, үйлчилгээ, бусад зориулалтаар ашигладаг, зарим сумдад 288 иргэн, ААНБ эзэмшлийн газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтаар 2 жил дараалан ашиглаагүй, газрыг хоосон хашаажуулсан, барилга дутуу барьж орхисон, Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Аудитаар нийт 98.1 сая төгрөгийн 20 зөрчил илрүүлж, 91,8 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж биелэлт 100 хувьтай байна. Мөн зөрчил арилгуулахаар 13 зөвлөмжийг өгснөөс 1 зөвлөмж тайлант хугацаанд хэрэгжсэн байна.

5 ИТХ-ЫН ЗАХИАЛГА, ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ

5.1 Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудит

Аудитыг аймгийн ТАГ-ын санаачилгаар 2019.01.02-2019.04.22 хүртэлх хугацаанд гүйцэтгэж, “Хөрөнгө оруулалтын төлөвлөлт хууль журмын дагуу хийгдээгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна” гэсэн дүгнэлт өглөө.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө Засаг даргын үйл ажиллагааны “**ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА**” 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймаг хөгжүүлэх хэтийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй, холбогдох байгууллагуудын санал дүгнэлтийг үндэслээгүй, хэрэгжиж дуусах хугацаа тодорхойгүй, төсөвт өртөг зөрүүтэй төсөл арга хэмжээнүүдийг оруулж батлуулсан байна.

Мөн хөрөнгө оруулалтын жагсаалт батлагдсаны дараа 3.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээний зураг төсвийг боловсруулж, хуульд заасан чиг үүрэгт хамаарахгүй, хөрөнгө оруулалтын бус зардлыг төлөвлөж батлуулсан байна.

Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт болон гэрээний дагуу гүйцэтгэх үүргээ бүрэн биелүүлээгүй, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, магадлашгүй ажлыг хянан баталгаажуулахгүй санхүүжилтийг олгожээ.

Аудитаар нийт 766.5 сая төгрөгийн 6 зөрчил илрүүлж, 2 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

5.2 Орон нутгийн өмчит компаниудын худалдан авах үйл ажиллагааны үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудит

Аймгийн ТАГ-ын санаачилгаар аудитыг 2019.05.01-2019.07.10 хүртэлх хугацаанд гүйцэтгэж, “Компаниудад худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгө, бараа материал, бэлэн мөнгөний төлбөр тооцоог холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгээгүйгээс хөрөнгө шамшигдах, хувьдаа ашиглах нөхцөл бүрдсэн байна” гэсэн дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3637,1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 19,8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоон, хэрэгжилт 100 хувь, барилга ашиглалтад оруулах тухай 1 албан шаардлага өгсөн бөгөөд тайлант хугацаанд бүрэн хэрэгжээд байна. Мөн 1195,6 сая төгрөгийн зөрчлийг шийдвэрлүүлэхээр хуулийн байгууллагад шилжүүлж, 2421,7 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгснөөс 364.4 сая төгрөгийн 8 зөвлөмж хэрэгжээд байна.



Тус аудитаар Чандмань Илч, Чандмань бадрал ОНӨХХК-иудын хөрөнгө бэлтгэхдээ МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн асуудлыг Авилгатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулж байна.

5.3 Дорноговь аймагт гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой МУ-д мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн сэдэвт нийцлийн аудит

Байгууллагын өөрийн санаачилгаар “Дорноговь аймагт гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой МУ-д мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт” нийцлийн аудитыг төлөвлөгөөний дагуу эхлэн гүйцэтгэж байсан бөгөөд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2 гүйцэтгэлийн аудит хугацааны хувьд зэрэг эхэлснээс байгууллагын хүний нөөцийн хүрэлцэхгүй байдлаас шалтгаалан тус аудитыг гүйцэтгэх хугацааг хойшлуулж, НДС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэлээ.

Тус аудитаар ГИХГ-ын Дорноговь аймаг дахь газарт 2019 оны 09-р сард албан томилолтоор ажиллаж аудитад шаардлагатай мэдээллийг авч, гадаадын иргэдийн Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг программаас тулгаж баталгаажуулсан.

Мөн гадаадын иргэдтэй гэрээ байгуулан хөдөлмөр эрхлүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгаа болон бусад мэдээллийн эх үүсвэрээс мэдээлэл цуглуулан ажиллаж байна.

ҮАГ болон НХХЯам, ХХҮЕГ-т гадаадаас ажиллах хүч ажиллуулсны төлбөрийн мэдээлэл авах талаар албан бичиг хүргүүлээд байна.

5.4 Аймгийн хэмжээнд Ашигт малтмалын тухай хууль хэрэгжиж буй байдал сэдэвт нийцлийн аудит

Тус аудитыг аймгийн ИТХ-ын захиалгаар 2019.11.01-2019.12.26 хүртэлх хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн шатанд байгууллагуудаас мэдээлэл цуглуулан эрсдэлийг үнэлж, асуудлын шинжилгээ, арга зүйг боловсруулж, төлөвлөгөө хөтөлбөр батлуулан, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажил хийгдэж байна.

6 ДОТООД АЖИЛ

6.1 Дотоод сургалт

Монгол Улсын Ерөнхий аудитор 2019 оныг “Аудитыг баримтжуулах бодлого, арга зүйг боловсронгуй болгож төлөвшүүлэх” жил болгон зарласан, манай газрын ажилтнуудын 54.5 хувь нь шинэ ажилтнууд бөгөөд тэдгээрт зориулсан мэдлэг олгох, ажлын байранд дадлагажуулах сургалтууд зайлшгүй шаардлагатай холбогдуулан дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан нийт 11 сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн.

Тайлант хугацаанд зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдлыг авч үзвэл:

ҮАГ-аас зохион байгуулсан удирдах ажилтны зөвлөгөөн, архив дотоод ажил болон мэдээллийн технологийн ажилтнууд, ахлах аудиторыг чадавхижуулах, сургагч багш бэлтгэх зэрэг нийт 5 сургалт зөвлөгөөнд 5 ажилтан хамрагдсан.

Сангийн яам, ТӨБЗГазар, аймгийн ЗДТГ, орон нутаг дахь бусад төрийн байгууллагуудаас зохион байгуулсан төрийн архив албан хэрэг хөтлөлт, статистикийн мэдээ тайлан гаргах, бүсчилсэн хөгжлийн бодлого төлөвлөлт, Төрийн албаны тухай хуулийн шинэчлэл, Төрийн өмчийн харилцааг зохицуулах дүрэм журмын өөрчлөлт, ХАС ХОМ мэдүүлэх тухай зэрэг чиглэлээр нийт 8 сургалтад давхардсан тоогоор 24 ажилтан хамрагдсан байна.

Мөн дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу “СТА-ыг хийхэд анхаарах асуудал”, “Дотоод удирдлагын программ хангамжийг хэрэглэх нь”, “Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийт ажиллагсдад сургалт зохион байгуулах”, “Төрийн архив, албан хэрэг хөтлөлт” сэдвээр тус тус дотоод сургалтыг зохион байгуулж, аудиторыг ажлын байранд чадваржуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.

6.2 Архив, бичиг хэрэг

МУ-ын Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамжийн дагуу архивын улсын үзлэг зохион байгуулагдахтай холбогдуулан дарга, тэргүүлэх аудиторов 2019 оны А/13 тоот тушаалаар 8 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилсон.

Тус комисс нь 17 зүйл заалт бүхий ажлын төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2003-2018 онуудын архивын баримтыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга, 70 жил, түр хадгалах нэгжээр нягтлан шалгаж, бүрдэл болгосон, мөн архивын өрөөг холбогдох стандартад нийцүүлэн засварлаж, 2,8 сая төгрөгийг зарцууллаа.

Аймгийн салбар комиссын урьдчилсан үзлэгт хамрагдаж “Хангалттай” үнэлэгдлээ.

6.3 Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа

Ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор ажлын байрны дасгалыг өдөр бүр хийж хэвшүүлсэн. Мөн 7 хоног бүрийн даваа гарагт спорт зааланд сагсан бөмбөг, гар бөмбөгөөр хичээллэх, ажлын байран дээр ширээний теннисний ширээ байрлуулж, ажилчдын спортоор хичээллэх нөхцөл боломжийг ханган ажиллаж байна.

6.4 Дотоод зохион байгуулалтын бусад асуудал

- Байгууллагын эцэг эхийн зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилон, 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталлаа.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2019 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, нийт 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.



- УАГ-ын audit.mn цахим хуудаст төрөлжсөн аудитын 147 тайлан, өдөр тутмын үйл ажиллагаа, зарын чанартай 10 мэдээллийг байршуулсан, мөн байгууллагын мэдээллийн самбарт санхүүгийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитын албадын тайлант онд хийсэн аудитын талаарх товч мэдээллүүдийг тогтмол шинэчлэн ажиллуулж байна.
- Аймгийн ИТХ-ын 31 төлөөлөгчийн мэйл хаягаар аудитын тайлангуудыг тогтмол хүргүүлж хэвшсэн.
- Аймгийн Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны сургалтад салбарын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал, шалтгаан, үр дагаврын талаар аудитор У.Оюунтүлхүүр мэдээлэл хийв.
- Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс Замын Үүд суманд зохион байгуулсан “Санхүүгийн ажилтнуудын зөвөлгөөн”-д аудитын менежер, САА-ны ахлах аудиторыг оролцуулж, ТЭЗ, ТТЗ, ТШЗ-чдын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн зөрчил, тогтоосон акт, албан шаардлагын талаар танилцуулсан мөн Төрийн аудитын байгууллагын үндсэн чиг үүрэг, дотоод аудитын байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны хувьд ялгаатай байдлын талаар мэдээлэл өглөө.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар 2019 онд дараах ажлуудыг шинээр санаачлан хэрэгжүүллээ. Үүнд:

- Сүүлийн 2 жилд аудиторчуудын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэхэд онцгой анхаарч, сурч боловсрох нөхцөлийг хангаж өгснөөр 2019 онд 2 аудитор шинээр Мэргэшсэн нягтлан бодогч болж нийт аудиторчуудын 75 хувь нь МНБ, 4 аудитор бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалж, нийт ажилтнуудын 66.6 хувь нь магистрын зэрэг цолтой болсон байна.
- Байгууллагын дотоодод зохион байгуулсан сургалтын тайлан, слайдыг тухай бүр бэлтгэн, нотлох баримтаар баталгаажуулж хэвшсэн байна.
- Цахим хуудсаар нийтэд мэдээлж буй мэдээллийн үнэн зөвийг хангах үүднээс бэлтгэсэн мэдээллийг дарга, тэргүүлэх аудиторроор хянуулан, байршуулж хэвшсэн.
- Архивын улсын үзлэгтэй холбоотой төсвийн нөөц бололцоонд тулгуурлан байгууллагын архивын өрөөг стандартад нийцүүлэн засварлан тохижуулж, аймгийн Архивын тасгаас өгсөн зөвлөмжийн дагуу архивын баримтад нягтлан шалгалтыг хийж, үзлэгээр “Хангалттай” дүгнэгдсэн байна.

7 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хөтөлж, 2019 оноос НББ-ийн үйл ажиллагаанд “Unicus” программыг ашиглаж байна.

Тайлант онд 275.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас ХБГ-ээр 255.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2 орон тоо дутуу ажилласнаас үүссэн 20.0 төгрөгийн цалингийн төсвийг УАГ-т төвлөрүүлээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аудитын үйлчилгээний төлбөрт нийт 66.8 сая төгрөг төвлөрч, ХАК-иудад 47.0 сая төгрөг олгоод байна.



Төрийн аудитын байгууллагын аудиторуудын гүйцэтгэсэн аудитын үйлчилгээний төлбөрөөс төвлөрүүлсэн 12,8 сая төгрөгийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан зарцуулах саналыг ҮАГ-т хүргүүлж, холбогдох шийдвэрийг үндэслэн 8.7 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх” гэрээг дүгнүүлж “95” үнэлэгдлээ.

Архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд байгууллагын архивын өрөөг холбогдох стандартад нийцүүлэн засварлаж нийт 2.8 сая төгрөгийг зарцуулаад байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, татвар, НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн бөгөөд, 2020 оны төсвийн төслийг ҮАГ-т хүргүүлээд байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд нийт 132 мэдээллийг хугацаанд нь тогтмол байршуулан, илгээж байна.

8 ДҮГНЭЛТ, САНАЛ

8.1 Дүгнэлт

2019 оны эхний хагас жилийн байдлаар санхүүгийн тайлангийн 217 аудит, ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 3 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, өөрсдийн санаачилгаар 2 гүйцэтгэлийн аудит, 1 нийцлийн аудит, аймгийн ИТХ-ын захиалгаар 1 аудитыг тус тус гүйцэтгэлээ.

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 117814,54 сая төгрөгийн 663 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 72403,6 сая төгрөгийн 120 алдааг залруулж, 187,9 сая төгрөгийн зөрчилд 72 төлбөрийн акт тогтоож, 14288,5 сая төгрөгийн зөрчилд 87 албан шаардлага хүргүүлж, 29422,1 сая төгрөгийн зөрчилд 366 зөвлөмж, 18,4 сая төгрөгийн зөрчилд 52 албан тушаалтанд хариуцлага тооцох 13 санал хүргүүлж, 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Тайлант онд тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг авч үзэхэд 151,19 сая төгрөгийн 47 төлбөрийн акт барагдаж, биелэлт 80,5 хувьтай, 6703,08 сая төгрөгийн 55 албан шаардлага хэрэгжиж, биелэлт 47 хувьтай, 21992,23 сая төгрөгийн 321 зөвлөмж хэрэгжиж /хугацаа болоогүй 2750,3 сая төгрөгийн зөвлөмжийн үлдэгдэлтэй байна/, биелэлт 74,7 хувийн хэрэгжилттэй байна.

Өмнөх онд тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг авч үзэхэд 32,3 сая төгрөгийн 23 төлбөрийн акт барагдаж, биелэлт 65,4 хувьтай, 2372,5 сая төгрөгийн 78 албан шаардлага хэрэгжиж, биелэлт 86,6 хувьтай байна.



Тайлант хугацаанд 1327.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 25 санхүүгийн бус үр өгөөж тус тус тооцсон бөгөөд 1 төгрөгт ногдох үр өгөөж 5.2 төгрөг болж байна.

Төсөвт байгууллагуудын санхүүгийн сахилга бат, төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах чиглэлийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүллээ.

- Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цагалбарт хугацаанд санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй 3 төсвийн шууд захирагчийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзаж, ТШЗ-ийн 1 тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн. Үүний мөрөөр 4 албан тушаалтанд хариуцлага тооцууллаа.
- Мөн Төсвийн тухай 6.4.8, 39.4.2-т төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалтыг зөрчиж төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс урьдчилан шилжүүлж авлага үүсгэсэн зөрчилд 172.2 сая төгрөгийн төлбөрийн акт, албан шаардлага тогтоолоо.
- Санхүүгийн тайлангийн аудитаар 2 байгууллагын нягтлан бодогч залилангийн шинжтэй зөрчил гаргасанд Сөрөг санал дүгнэлт өглөө. Тус зөрчлийн мөрөөр Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодогчийн асуудлыг Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Мөн аймгийн Прокурорын газрын нягтлан бодогчид эрүү үүсэн шалгагдаж, эцэлсэн шийдэгдээгүй байгаа тул тухайн асуудал шийдэгдэх хүртэл арга хэмжээ давхардуулж аваагүй байна.

8.2 Санал

1.МУ-ын Ерөнхий аудиторов 2018 оны А/235 дугаар тушаалаар төрийн аудитын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулах, тайлагнах журам шинэчлэгдэн батлагдсан. Тус журмаар бүртгэл, нэгтгэл, статистикийн мэдээний нийт 30 маягтыг хөтлөх болсон нь хэт ачаалал үүсгэж байгаа учир статистик мэдээний нэгдсэн программ хангамжтай болгох саналыг уламжилж байна.

2.Одоогоор аудитын менежер хүүхэд асрах чөлөөтэй тул ахлах аудитор аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэхийн зэрэгцээ аудитаа гүйцэтгэж байгаа нь ажлын өндөр ачаалалтай ажиллаж, чанарын хяналт сулрах эрсдэлтэй байна. Мөн 2019 онд 1 сул орон тоонд томилгоо хийх асуудал шийдэгдээгүйгээс бусад аудиторуд ч ачаалалтай ажиллалаа. Иймд боловсон хүчнийг гэрээгээр ажиллуулан дадлаажуулж, тэдгээрээс орон тоог нөхдөг байх бодлогыг бий болгох нь зүйтэй байна.

3.Нягтлан бодогч, архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан санхүү төсвийн талаар хариуцлага хүлээж хоёрдугаар гарын үсэг зурдаг, архив, бичиг хэргийн өндөр ачаалалтай, хариуцлагатай ажил гүйцэтгэдэг боловч гэрээт ажилтан гэсэн шалтгаанаар цалин бага, нэмэгдэл хөлс авдаггүй, бусад нийгмийн асуудал шийдвэрлүүлэх боломжгүй байгаагаас тус ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллахгүй байна. Иймд Нягтлан бодогч, архив, бичиг хэрэг хариуцсан ажилтны ажлын байрыг орон тооны болгох саналыг хүргүүлж байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА



Дорноговь аймаг, Сайншанд сум

Орон нутгийн өмчийн III байр



dornogovi.audit.mn



dornogovi@audit.gov.mn



70522734, 70523020